

ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН



/2019 оны жилийн эцсийн байдлаар/

1. “ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ ХӨТӨЛБӨР-5” ТӨСӨЛ

Орхон аймаг. Эрүүл мэндийн газар

2019.01.08

№	Төсөл хөтөлбөрийн агуулга	гүйцэтгэл		
1	Төсөл хөтөлбөрийн нэр огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана.)	Төсөл хөтөлбөрийн нэр: Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр -5 хүрээнд Орхон БОЭТ-ийн Нянд судлалын лаборатори, төвлөрсөн ариутгалын үйл ажиллагааны шинэчлэл		
2	Санхүүгийн эх үүсвэр	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр -5 төсөл		
3	Хэрэгжүүлэгч байгууллага/хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Бүсийн оношилгоо эмчилгээний төв Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Азийн хөгжлийн банк, Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр-5 төсөл		
4	Төсөл хөтөлбөрийн зорилтууд	Зорилт-1 Эмнэлгийн халдвараас сэргийлэх, хянах		
5	Зардал	1. Нийт 1 тэр бум 235,100 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, Нянд судлалын лабораторийн их засвар, тоног төхөөрөмж 347,7 сая, Төвлөрсөн ариутгалын их засвар, тоног төхөөрөмж 887,4 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн		
	Төсөв (нийт шаардагдах зардал)	Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь
	Багц 1	Эмнэлгийн халдвараас сэргийлэх, хянах	1,235,100,000 сая төгрөг	100%
6	Төсөл хөтөлбөрийн зорилт	Хэрэгжилт		
	Төсөл хөтөлбөрийн зорилт-1 Өвчтөн, эмнэлгийн ажилтны аюулгүй байдлыг сайжруулах, Эмнэлгийн халдвараас сэргийлэх, хянах	Төслийн хүрээнд: <ul style="list-style-type: none"> ✓ Микробиологийн лабораторийг сайжруулах ✓ Ариутгалын тусламж үйлчилгээг сайжруулах ✓ Эмнэлгээс шалтгаалах халдварын тандалтын идэвхтэй тогтолцоог бий болгох ✓ Хүний нөөцийг чадавхижуулах зэрэг 4 чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан. Уг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Азийн хөгжлийн банкнаас нийт 1 тэрбум 235,100 сая төгрөгийн санхүүжилт зарцуулагдаж, их засвар болон тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нийлүүлэгдсэн. Нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн ашиглалтаар ЭМСХХ-5 төслийн багийн холбогдох инженерүүд тоног төхөөрөмжийн үзлэг хийж, тоног төхөөрөмжийн ашиглалт 100%-тай байна.		

		<p>Төсөл хэрэгжих хугацаанд 2 удаа олон улсын болон Азийн хөгжлийн банкнаас хамтарсан хяналтууд хийгдэж зөвлөмж өгсөн.</p> <p><u>Нян судлалын лабортатори тайлант жилд:</u> 30.000 хүнд Онош, урьдчилан сэргийлэх, тандалт, голомтын 52,000 шинжилгээ 5100 АМЧ шинжилгээ хийгдсэн.</p> <p><u>Ариутгалын тасаг тайлант жилд:</u> 1700 бикс ариутгаж, 148000 багаж угааж, 266000 боолтын сальфетка, 655000 хөвөн бөмбөлөг тасаг нэгжүүдэд олгож ажилласан.</p> <p>Тус төсөл хэрэгжсэнээр:</p> <ol style="list-style-type: none"> 1. Цус өсгөвөрлөх ВаСТ alert 3d 60 автомат төхөөрөмж нийлүүлсэн. Уламжлалт аргатай харьцуулахад хариу 1-3 хоногоор хурдан гардаг болсон. 2. Чанарын хяналтын АТСС 6 төрлийн омог нийлүүлсэн. Олон улсын стандарт омгоор дотоод хяналт явуулах боломж бүрдсэн. 3. 40 Стандарт ажиллагааны заавраар хангасан. Өөрийн үйл ажиллагаанд нийцүүлэн боловсруулж, батлуулан, дагаж мөрдөн ажиллаж, хэрэгжилт 90%-тай байна. 4. -20⁰С хөлдөөгчтэй болсноор өсгөвөрийн сан бүрдүүлэх нөхцөл бүрдсэн. Одоогийн байдлаар 30 гаруй өсгөвөр хадгалагдаж байна. 5. D test буюу Клиндамицины өдөөгддөг тэсвэржилтийг илрүүлдэг болсон. 6. Гэдэсний эмгэгтөрөгч илрүүлэх Hektoen enteric агар хэрэглэж эхэлсэн. Илрүүлгийн хувь нэмэгдсэн 7. Сорьцын чанарт өндөр шаардлага тавьдаг болсон. Цэрэнд Q оноо үнэлж шаардлагагүй сорьцод шинжилгээ хийхгүй байна. 8. СО2 термостаттай болсноор агааргүйтэн бактери өсгөвөрлөх боломж бүрдсэн. 9. Ариутгалын чанар, хяналт сайжирсан <div style="display: flex; justify-content: space-around; align-items: center;">   </div>
7	<p>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<p>Ололт:</p> <ul style="list-style-type: none"> - Шинжилгээний чанарт гарсан ахиц, үр дүн гарсан. - Ариутгалын чанар, хяналт сайжирсан. - Өвчтөн, эмнэлгийн ажилтны аюулгүй байдлыг сайжирсан. <p>Анхаарах асуудал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ашиглагдах халдваргүйжүүлэх бодис, багаж угаалгын уусмал, урвалж оношлуурын өртөг өндөр байгаа нь тулгамдаж буй асуудал болоод байна.

		2. Шинээр суурьлагдсан тоног төхөөрөмжийн хэвийн тогтвортой ажиллагааг хангахын тулд урвалж, угаалгын бодис, урсгал засвар, тохируулга гэх мэтэд зарцуулагдах зардлын төсвийг нэмэгдүүлэх шаардлага байна.		
8	Төсөл хөтөлбөрийн хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	1. Төсөл хэрэгжих хугацаанд жилд 2 удаа олон улсын болон Азийн хөгжлийн банкнаас хамтарсан хяналтууд хийгдэж зөвлөмж өгч байсан. 2. Нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн ашиглалтаар ЭМСХХ-5 төслийн багийн холбогдох инженерүүд тоног төхөөрөмжийн үзлэг хийж ашиглалт 100%-тай болсон.		
9	Зорилт 2 Төсөл хөтөлбөрийн хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх	1.Төсөл хэрэгжих хугацаанд жилд 2 удаа ЭМСХХ-5 төсөл, ХӨСҮТ-тэй хамтарсан хяналтууд хийгдэж заавар, зөвөлгөө, зөвлөмж өгч байсан. 2.Цаг тухай бүр холбогдох сургалтууд хийгдэж тоног төхөөрөмжийн инженерүүд ирж заавар зөвөлгөөг өгч ажилласан.		
9	Төсөл хөтөлбөрийг хэрэгжилтийн үнэлгээ дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	хувь
		100%	1	100%
10	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ		

2.“АНХАН БА ХОЁРДАХ ШАТЛАЛИЙН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ” ТӨСӨЛ

№	Төсөл хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл			
1	Төсөл хөтөлбөрийн нэр: Огноо, шийдвэрийн дугаар:	Төслийн нэр: Анхан болон хоёрдох шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах Огноо, шийдвэрийн дугаар: ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн Мэргэжилтний Хөгжлийн Зөвлөлийн 2019 оны 10-р сарын 18-ны өдрийн 12 дугаар тогтоол			
2	Санхүүгийн эх үүсвэр	“Жайка” Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламж			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Бүсийн оношилгоо эмчилгээний төв Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ЭМЯ, ЭМХТ, Орхон аймгийн ЗДТГ, ЭМГ, Сургалт эрхлэх сүлжээ эмнэлэгүүд-Медипас эмнэлэг, Мэндцэцэн, Үйлсбадрах ӨЭМТ, Жаргалан СЭМТ Хэрэгжих хугацаа: 2015-2020 он			
4	Төсөл хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Сургалт зохион байгуулах, хянах чадавхийг сайжруулах Зорилт 2.Сургалтын хөтөлбөр боловсруулах Зорилт 3. Орон нутагт сургалтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх			
5	Зардал	Төсөв	Нийт 48.0 сая төгрөг		
Үүнд:		Төсөв (2018 он)	Гүйцэтгэл	Хувь	Тайлбар
Багц 1		Орон нутаг	40.0 сая	100%	Сургалтын тоног төхөөрөмж, эд материал
Багц 2		Жайка Японы олон улсын хамтын ажиллагааны	8 сая	100%	Сургалтын компьютер, прентир

	байгууллага	
Төсөл хөтөлбөрийн зорилт		Хэрэгжилт
<p>1-р дүгээр зорилтын хүрээнд Хүрэх үр дүн: ЭМЯ болон ЭМХТ-н төгсөлтийн дараах сургалтын удирдлага, зохион байгуулалтын чадавхи сайжирна.</p>		<p>Монгол Улсын ЭМЯ-наас ЖАЙКА ОУ-ын байгууллагад тавьсан хүсэлтийн дагуу 2015 оноос энэхүү төслийн үйл ажиллагаа эхэлсэн. Сургалт зохион байгуулах, хянах чадавхийг сайжруулах чиглэлээр 2016 онд Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хууль батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/ 337 тоот тушаалд заагдсанаар хүний их эмч нь төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын нэг жилийг Ерөнхий мэргэшил судлал сургалтад суралцах болсон. Уг төслийн хүрээнд Япон Улсын төгсөлтийн дараах сургалтын тогтолцоонд үндэслэн, Монгол Улсад төгсөлтийн дараахь сургалтыг үр дүнтэй сайжруулахын тулд ЭМЯ болон ЭМХТ-тэй хамтран, төгсөлтийн дараахь сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлага, сургалт эрхлэх байгууллагын үйл ажиллагаанд явцын үнэлгээ хийх шалгуур, суралцагч эмчийн үнэлгээний аргачлалыг сайжруулах зэрэг үйл ажиллагааг явууллаа.</p>
<p>2-р дүгээр зорилтын хүрээнд Хүрэх үр дүн: Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр боловсронгуй болно.</p>		<p><u>Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалт:</u> Япон Улсын “Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам”-ны удирдамжийн дагуу зохион байгуулагддаг сургагч багшийн сургалтын агуулгад үндэслэн Монгол Улсын сургагч багшийг бэлтгэх TOT сургалтын хөтөлбөрийг боловсруулж, TOT сургалтыг явуулах, зохион байгуулах чиглүүлэгч багш нарыг сургаж бэлтгэсэн. Сургалт эрхлэх байгууллага нь төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулахын тулд багш нар нь TOT сургалтад зайлшгүй хамрагдсан эмч нар байх шаардлагатай тул сургалт эрхлэх байгууллага болох эмнэлгүүдийн сургагч багш нарыг бэлтгэхийн тулд энэхүү сургалтыг ЭМХТ-тэй хамтран сар бүр зохион байгуулан ажилласан. Орхон аймгийн хувьд TOT сургагч багш бэлтгэх сургалтыг ЭМЯ, ЭМХТ, ЖАЙКА төслийн багтай хамтран нийт 6 удаа зохион байгуулж, БОЭТ-ийн 38 эмч, сүлжээ эмнэлгийн 14 эмч бэлтгэгдэн эмнэлзүйн сургалт удирдан явуулах бүрэн боломжтой болсон. 2018 оны 9 сард БОЭТ-ийн үндэсний чиглүүлэгч багш нарын анх удаа, бие даан удирдсан TOT сургалтад шинээр сүлжээ эмнэлгийн эмч нарыг оролцуулаад 24 сургагч багшийг амжилттай бэлтгэлээ.</p> <div data-bbox="801 975 1957 1362"> </div> <p><i>Зураг 1, 2 БОЭТ-ийн үндэсний чиглүүлэгч багш нарын анх удаа бие даан удирдсан TOT сургалт</i> Төгсөлтийн дараах сургалт эхлэхээс өмнө Монгол Улсын сургалт эрхлэх эмнэлгийн эмч нараас Япон Улсын эмнэлэгт явагддаг төгсөлтийн дараах сургалтын явцтай танилцаж, сургалтын давуу тал</p>

болоод хэрэгжүүлбэл зохих зүйлийн талаар суралцаж, одоогийн сургалтын үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхлээд байна. Одоогийн байдлаар Орхон аймгаас 5 удаа 7 эмч нар тус Япон дахь сургалтад хамрагдсан.



Зураг 3, 4. Япон Улсын төгсөлтийн дараах сургалт

Ерөнхий мэргэшил судлалын сургалтын хөтөлбөр боловсруулах:

Дэлхийн чиг хандлагыг даган, чадамжид суурилсан хөтөлбөрийн загварыг үндэслэн Монгол Улсын орон нутагт ажиллах чадвар бүхий ерөнхий мэргэшлийн эмчийн эзэмших шаардлагатай чадамжийг (competency) олгох хөтөлбөрийг боловсруулж ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөр 2018 оны 5 сард батлуулсан. Энэхүү батлагдсан хөтөлбөрийн дагуу Монгол улсад анх удаа Орхон аймгийн БОЭТ нь сургалтын эмнэлгийн зөвшөөрөлтэйгээр 2018 оны 10 сараас Ерөнхий мэргэшил судлалын сургалтыг загвар болгон зохион байгуулж эхэлсэн.

Тасралтгүй сургалтын багцыг боловсруулах:

Төслийн хүрээнд эмч нарын тасралтгүй сургалтын багцыг боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажилласан. Японы мэргэжилтний зааварчилгаагаар яаралтай тусламжийн сургалтын багцыг боловсруулж, сургалтыг монгол эмч нар удирдан зохион байгуулж байна. Түүнчлэн эмнэлгийн мэргэжилтний халдварын сэргийлэлт, яаралтай тусламж, хүүхдийн өвчин судлал, ёс зүйн сургалтуудыг тус тус зохион байгуулан хамтран ажилласан.

3-р дүгээр зорилтын хүрээнд

Хүрэх үр дүн: Загвар аймгийн эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын систем тогтвортой болно.

Орон нутагт сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

Орон нутагт сургалт зохион байгуулах чадавхийг сайжруулахаар төслийн загвар аймаг болох Орхон аймгийн БОЭТ, ЭМГ-тай хамтран ажиллаж байна. Төслийн салбар нэгжийг Орхон аймгийн БОЭТ-д 2018 оны 5 сараас байгуулж, олон улсын стандартад нийцсэн чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцагч эмчийн үнэлгээний аргыг боловсруулах, сургагч багш нарыг бэлтгэх, сургалт эрхлэх байгууллагын сургалтын албыг чадавхижуулах, тойролт тус бүрийн сургалтын төлөвлөгөө, сургалтын гарын авлага боловсруулах гэх зэргээр “ерөнхий мэргэшил судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалтын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Сургалтад хэрэглэх сургалтын

материалуудыг ЖАЙКА, Японы Олон Улсын Эрүүл Мэнд Анагаах Ухааны Үндэсний Төвийн ОУ-ын ЭМ-ийн хамтын ажиллагааны газрын хүүхдийн болон ЭБЭ-ийн эмч нар, GENEPRO байгууллагатай хамтран боловсруулж, ЭМЯ-ны харьяа салбар мэргэжлийн зөвлөлөөр тус тус батлуулан сургалтад хэрэглэж байна. Мөн гардан үйлдэлийн гарын авлага болон видео хичээлийг тус тус бэлтгэж байна.



Зураг 5. Хүүхдийн судлалын тойролтын гарын авлагыг боловсруулсан ажлын хэсэг

Зураг 6. Эх барих эмэгтэйчүүд судлалын тойролтын гарын авлагыг боловсруулсан ажлын хэсэг



Зураг 7, 8. Төгсөлтийн дараах хөтөлбөрт тусгагдсан зайлшгүй суралцах гардан үйлдлийн гарын авлага болон видео боловруулах ажлын хэсэг

БОЭТ-ийн захирлын тушаалаар томилогдсон “Төгсөлтийн дараах сургалтын хяналтын зөвлөл” ажиллаж, Ерөнхий мэргэшил судлалын сургалтын журам, хөтөлбөр, төлөвлөгөө, хуваарийг хэлэлцэн батлаж, төгсөлтийн дараах сургалтын хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан. БОЭТ-ийн болон Сүлжээ эмнэлгийн сургалтын хяналтын зөвлөл нь өнгөрсөн хичээлийн жилд нийт 7 удаа хуралдаж, сургалттай холбоотой 38 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.



Зураг 9, 10 Сургалтын хяналтын зөвлөлийн хурал

2018 оны 10-р сарын 18-ны өдөр ЭМЯ-ны эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл хуралдаж Орхон аймгийн БОЭТ-ийг сургалт эрхлэх эмнэлгээр баталж 10 дугаар сарын 22-ны өдрөөс Ерөнхий мэргэшил судлалын сургалтыг эхүүлсэн. Сургалтын нээлтийн үйл ажиллагаанд төслийн гол хамтрагч талууд болох ЭМЯ-ны холбогдох удирдлага, аймгийн удирдагууд оролцож сургалтыг эхлүүлсэн. Тус сургалтаар 4 суралцагч нэг жилийн турш дотор, хүүхэд, төрөх эмэгтэйчүүд, яаралтай тусламжийн чиглэлээр тойрч суралцан, орон нутагт тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, гардан үйлдлийг эзэмшин суралцаж 2019 оны 9 дүгээр сард төгссөн.



Зураг 11. Ерөнхий мэргэшил судлалын Төгсөлтийн арга хэмжээ ЭМХТ болон БОЭТ

2019 оны 10 сараас төслийн загвар эмнэлэг болох Орхон аймгийн БОЭТ-д Ерөнхий мэргэшил судлалын 2 дахь удаагийн сургалтад 5 суралцагч эмч нар элсэн суралцаж байна.



Зураг 12. Ерөнхий мэргэшил судлалын 2019-2020 оны хичээлийн жилийн нээлт

2019 оны 6-р сард Эрүүл мэндийн хөгжлийн төв болон Орхон аймгийн БОЭТ-д уулзалт сургалтыг зохион байгууллаа. Энэхүү сургалтанд Ховд, Өвөрхангай, Өмнөговь болон Дорнод аймгийн БОЭТ, мөн Нийслэлийн хоёр дүүргийн эмнэлгийн сургалт хариуцсан мэргэжилтнүүд оролцож туршилга солилцлоо.



Зураг 13. Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн Сургалтын албаны хамт



Зураг 14. Ховд, Өвөрхангай, Өмнөговь болон Дорнод аймгийн БОЭТ, мөн Нийслэлийн хоёр дүүргийн эмнэлгийн сургалт хариуцсан мэргэжилтнүүдийн хамт

Сургалтын хугацаанд ЭМЯ болон ЭМХТ-ийн үнэлгээ

ЭМЯ, ЭМХТ-өөс Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх Сургалт эрхлэх байгууллагын зөвшөөрөл хүсэхтэй холбоотой бэлтгэл ажлын явцтай танилцах, дэмжлэгт хяналтыг 2017, 2018 онуудад тус тус хийгдсэн. 2018 оны 10 сараас эхлэн явагдаж буй Ерөнхий мэргэшил судлалын сургалтын хэрэгжилтийн талаарх үнэлгээг 2019 оны 6 сард Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ)-ийн мэргэжилтэн ирж үнэлгээг хийсэн. Үнэлгээ нь сургалтын зохион байгуулалт, хяналтын тогтолцоо, сургалтын орчин (сургалтын өрөө, тоног төхөөрөмж), суралцагч эмчийг дэмжих орчин,

		<p>сурган заах бүтэц, хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай, суралцагч эмчийн үнэлгээ зүй зохистой хийгдэж байгаа эсэх зэрэг нийт 60 гаруй шалгуураар хийгдэж, БОЭТ нь улсын хэмжээнд сургалт эрхэлж буй эмнэлэгүүдээс хангалттай сайн түвшинд үнэлэгдлээ.</p> <p><u>“Жайка” төв Азийн олон улсын үнэлгээний багийн үнэлгээ:</u></p> <p>“Жайка” төв Азийн олон улсын үнэлгээний багийн мэргэжилтнүүд Орхон аймгийн БОЭТ-д нийт 3 удаа хүрэлцэн ирж (2017, 2019 оны 3, 10 сар) ирж, төгсөлтийн дараах сургалт хэрэгжүүлж эхлэх бэлтгэл ажил болон сургалтын явцын үнэлгээг тус тус хийж төслийн явцыг хангалттай гэж үнэллээ.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div>				
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон ололттой тал, дутагдалтай талуудыг бичнэ.				
8	Төсөл хөтөлбөрийн хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	ЭМЯ, ЭМХТ, Жайка төв Азийн олон улсын үнэлгээгээр хангалттай сайн үнэлэгдсэн.				
9	Төсөл хөтөлбөрийг хэрэгжилтийн үнэлгээ дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж 100%	Зорилтын тоо 3	Зорилт1 100%	Зорилт 2 100%	Зорилт 3 100%
10	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ				

3.“СҮРЬЕЭГИЙН ТОХИОЛДЛЫГ ЭРТ ИЛРҮҮЛЭХ ДАДЛЫГ ДЭМЖИХ ЗАМААР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ, ӨВЧТӨН ТӨВТЭЙ НЭГДСЭН ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛЛАГААГ БҮРДҮҮЛЖ ХЭВШҮҮЛЭХ, ЭМИЙН ДАСАЛТТАЙ СҮРЬЕЭГИЙН АЮУЛД АНХААРАХ” ТӨСӨЛ

№	Төслийн агуулга		“Сүрьеэгийн тохиолдлыг эрт илрүүлэх дадлыг дэмжих замаар үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, өвчтөн төвтэй нэгдсэн халамж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажиллагааг бүрдүүлж хэвшүүлэх, эмийн дасалттай сүрьеэгийн аюулд анхаарах”		
1	ДОХ, Сүрьеэгийн төсөл		Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БОЭТөв		
2	Санхүүжилтийн эх үүсвэр		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Монгол улс эрүүл мэндийн яам, Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг		
3	Хэрэгжүүлэгч байгууллага, хэрэгжих хугацаа	нийт	Хэрэгжих хугацаа: 2018-2021 он Б.Энхтуяа МСТН-Орхон аймаг хариуцсан сүрьеэгийн төслийн ажилтан утас:86208188 enkheerdenet@yahoo.com		
4	Төслийн зорилтууд		Зорилт 1. Эрт илрүүлэлт болон шууд хяналттай богино хугацааны эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах. Зорилт 2. Олон эмэнд дасалтай сүрьеэг эрт илрүүлэх, тусламж үйлчилгээг өргөжүүлэх Зорилт 3. Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, ялгаварлан гадуурхалтыг бууруулах Зорилт 4. Нийт хүн амд сүрьеэгийн чанартай тусламж үйлчилгээг тэгш хүргэх		
5	Зардал	Төсөвт шаардагдах нийт зардал	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
		Үүнд:	Эмийн төсөв Глобаль сан-50,0 сая	25523103,1 сая	100%
		Багц:1	Буцалтгүй тусламж	472200	100%
		Багц 2	Гэрийн эмчилгээ	781200	100%
6	Төсөл хөтөлбөрийн зорилт		Хэрэгжилт		
	1-р зорилт: Эрт илрүүлэлт болон шууд хяналттай богино хугацааны эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах. Хүрэх үр дүн: Сүрьеэгийн илрүүлэлтийг нэмэгдүүлж, эмчилгээний үр дүнг 90 хувьд хүргэж, нас баралтыг 2015 оны үзүүлэлтээс 30 хувиар бууруулна.		Сүрьеэгийн өвчлөл 10000 хүн амд 7 промилл буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 промиллоор нэмэгдсэн. Сүрьеэгийн үзлэгт 5584 хүн хамрагдсанаас 94,3% нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,8 хувиар нэмэгдсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд орон нутгаас дижитал аппарат, Глобаль сангийн санхүүжилтээр GENE-xpert аппаратыг ЭМЯ-наас нийлүүлсэн нь сүрьеэ өвчнийг цаг алдалгүй эрт илрүүлэх, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн. 2019 оны байдлаар 662 сорьц шинжлэн уушигны халдвартай хэлбэрийн 47 тохиолдол илрүүлсэн, дижитал аппаратаар 17802 хүн үйлчлүүлснээс 13635 буюу 74.9% цээжний зураг авахуулсан байна. Орхон аймгийн хүүхдийн сүрьеэ 2015 онд 7 байсан бол 2019 онд хүүхдийн өвчлөл 2 болж буурсан байна. Өнөөгийн байдлаар нийт 38 хүн эмчилгээ хяналтад байна. Халдвартай болон олон		

		<p>эрхтэн хамарсан сүрьеэгийн хүнд хэлбэрээр эмчилгээ хяналтад орж буй хүмүүсийг сүрьеэгийн тасагт 100% хэвтүүлэн эмчилж хянаж ажилласан. Нийт эмчлүүлэгчдийг ХДХВ шинжилгээнд 90% хамруулсан. Эмчилгээний амжилт 86,1% байна.</p>
	<p>2-р зорилт: Олон эмэнд дасалтай сүрьеэг эрт илрүүлэх, тусламж үйлчилгээ өргөжсөн байна</p> <p>Хүрэх үр дүн: Олон эмэнд болон рифамицинд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдлын эмчилгээний үр дүн нэмэгдэнэ.</p>	<p>Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран “Сүрьеэгийн эмэнд тэсвэржилтийн үндэсний тандалт судалгаа”-гаар олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн 3 тохиолдол эрт үед нь илрүүлсэн.</p> <p>2019 онд эмэнд тэсвэртэй байж болзошгүй тохиолдлыг ялган оношлох шинжилгээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвд 244 сорьц хүргүүлэн байна. Одоогийн байдлаар олон эмэнд тэсвэртэй сүрьеэтэй 9 хүн эмчилгээний хяналтад эмчлүүлж байгаагаас тус онд шинээр 4 тохиолдол оношлогдсон. Шинээр оношлогдсон тохиолдол бүрийг цаг алдалгүй, хүлээгдэлгүй эмчилгээнд хамруулсан.</p>
	<p>3-р зорилт: Хүн амын сүрьеэгийн талаарх мэдлэг хандага, дадал өөрчлөгдсөн байна.</p> <p>Хүрэх үр дүн: Иргэдийн мэдлэг мэдээлэл сайжирсан байна.</p>	<p>Аймгийн Засаг даргын А/476 дугаар захирамжаар “Сүрьеэгүй аймаг” ухуулга нөлөөллийн уулзалтыг удирдах түвшний 46 хүнийг хамруулан зохион байгуулж, сүрьеэгээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлсэн. “Хүүхдийн сүрьеэ өвчний оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн ур чадварыг сайжруулах нь” сэдэвт төвийн бүсийн сургалтыг зохион байгуулж, 7 аймгийн 45 эмч мэргэжилтэн, сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтад 542 зорилтот бүлгийн хүнийг хамруулан мэдлэгийг дээшлүүлсэн. Ухуулга нөлөөллийн үйл ажиллагааны дүнд сүрьеэгийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралт 94,3%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,8 хувиар нэмэгдсэн байна.</p>
	<p>4-р зорилт Эмзэг бүлгийн бүлгийн хүн амд хүрэх сүрьеэгийн тусламж үйлчилгээ өргөжсөн байна.</p> <p>Хүрэх үр дүн:</p>	<p><u>МСТН-ийн Орхон аймаг дахь салбар нь 2004 оноос эхлэн Глобаль сангийн дэмжлэгтэй “Сүрьеэгийн тохиолдлыг эрт илрүүлэх дадлыг дэмжих замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, өвчтөн-төвтэй нэгдсэн халамж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажиллагааг бүрдүүлж, хэвшүүлэх, эмийн дасалтай сүрьеэгийн аюулд анхаарах” төслийн хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> - <u>Сайн дурын идэвхитэнг сургаж бэлтгэн өвчтөний эмийг гэрээр харж уулган 2019 онд 62 хүнийг хамруулан ажиллаж байна.</u> - <u>МСТН-тэй хамтран амьдралын баталгаажих түвшин доогуур орлоготой 1 өвчтөнд эмчилгээний турш нэмэлт хүнсний бүтээгдэхүүнийг сар бүр олгож байна.</u> - <u>Сүрьеэгээр өвдсөн болон түүний ар гэрийхэн, эмчлэгдээд эдгэрсэн хүмүүсийн хооронд “Дэмжигч бүлгийн уулзалт”-ыг сар бүр зохион байгуулж 120 хүн хамрагдсан.</u> - <u>Тайлант хугацаанд сайн дурын 7 ажилтан нийт 840 хүнээс асуумж авснаас 155 хүнд илгээх хуудас тасалж, үүнээс 7 шинэ сүрьеэ илрүүлж эмчилгээнд хамруулсан.</u>

12	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудал)	<p>Ололттой тал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нийт сүрьеэгийн үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралт 94,3%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,8 хувиар нэмэгдсэн. 2. Орон нутгийн төсвөөс сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэг зохион байгуулахад 4.75 сая төгрөгийн санхүүжилт олгож зорилтот бүлгийн 500 хүнийг хамруулж сүрьеэгийн 9 шинэ тохиолдол илрүүлсэн. 3. Глобаль сангийн санхүүжилтээр 2018 онд 52.73 сая төгрөгийн өртөг бүхий GENE-xpert аппаратыг хангасан нь сүрьеэ өвчнийг түргэн хугацаанд оношлох боломжийг бүрдүүлсэн. <p>Тулгамдаж буй асуудал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд улсын төсөв, орон нутгийн төсвөөс оношилгоо болон эмчилгээний зардалд хөрөнгө оруулалт нэмэгдэхгүй байна. 2. Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чиглэлээр үйлчлэх хүрээний хүн амд ноогдох эмчийн тоо дутагдалтай, дисдансерийн халдвар хяналтын тогтолцоо бэхжээгүй байна. 3. Салбарын байгууллагын оролцоо сул, уялдаа холбоог сайжруулах шаардлага байна. 					
13	Төсөл хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хамтын оролцоо сул байна.					
14	Төслийн хэрэгжилтийн үнэлгээ дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
		100%	4	100%	100%	100%	100%

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: МЭРГЭЖИЛТЭН

Д.ОТГОНДЭЛГЭР

ТАНИЛЦСАН: ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ